

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-13

- 
1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/ 4-8
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/ 8-13

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
11 дүгээр сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 40 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Саранчулуун;  
Чөлөөтэй: Б.Хэрлэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: С.Эрдэнэбат.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ч.Ундрам төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Байнгын хорооны дарга Ч.Ундрам, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

**Ч.Ундрам:** “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 1

Бүгд: 11  
90.9 хувийн саналаар батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн саналыг дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ч.Ундрам төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар, М.Сарнай, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах үг хэлэв.

**Ч.Ундрам:** “Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 0  
Бүгд: 12  
100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 31 минут үргэлжилж, 15 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 11 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим,  
14 цаг 40 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ч.Ундрам:** Боловсрол, соёл,  
шинжлэх ухаан, спортын байнгын  
хорооны 2024 оны 11 сарын 13-ны  
өдрийн хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооноос ирвэл зохих  
15 гишүүнээс 10 гишүүн ирж, ирц 66,7  
хувьтай байна.

Отгоншарын Батнайрамдал  
ирсэн байна. Дуламын Бум-Очир ирсэн.  
Шинэбаярын Бямбасүрэн ирсэн.  
Жанчивын Галбадрах ирсэн байна.  
Амгаланбаатарын Ганбаатар ирсэн  
байна. Гонгорын Дамдинням чөлөөтэй.  
Бадрахын Найдалаа ирсэн байна.  
Цэндсүрэнгийн Мөнхтуяа ирсэн.  
Дүгэрийн Рэгдэл ирсэн. Отгоны  
Саранчулуун чөлөөтэй. Мягмардашийн  
Сарнай ирсэн. Чинбатын Ундрам  
ирсэн. Ганбатын Хосбаяр ирээгүй  
байна. Бадарчийн Хэрлэн чөлөөтэй.  
Сүхбаатарын Эрдэнэбат чөлөөтэй.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

1 дүгээрт, Төрийн өмчийн  
ерөнхий боловсролын сургууль,  
цэцэрлэг, дотуур байрны нүхэн  
жорлонг орчин үеийн стандарт,  
шаардлагад нийцсэн ариун цэврийн  
байгууламжаар солих ажлын явцад  
дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн үйл  
ажиллагааны удирдамжийг батална.

2 дугаарт, Боловсролын зээлийн  
сангийн үйл ажиллагаа, журмын

биелэлтэд хяналт шалгалт хийх,  
холбогдох санал, дүгнэлт гаргах ажлын  
хэсгийн үйл ажиллагааны удирдамж  
батална.

Ийм 2 асуудал байна.

Тэгээд манай дэгийн тухай  
хуульд өөрчлөлт орсон учраас ажлын  
хэсэг байгуулагдах тутамд ажлын  
хэсгийн ажиллах удирдамжийг  
Байнгын хороогоор заавал оруулж  
баталдаг ийм дэгтэй болсон учраас  
өнөөдөр ажлын хэсгүүд ярилцаад,  
удирдамжийнхаа төслийг та бүхэнд  
хүргүүлээд, тэгээд өнөөдөр хэлэлцээд  
баталдаг ийм болсон байгаа шүү  
гэдгийг хэлмээр байна.

Хэлэлцэх асуудал дээр өөр  
саналтай гишүүд байна уу? Байхгүй  
байна.

Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хэлэлцэх асуудалдаа орё.

**1. Ажлын хэсэг 2024 оны 10  
сарын 30-ны өдөр хуралдаж, “Ажлын  
хэсгийн үйл ажиллагааны удирдамж  
батлах тухай” Байнгын хорооны  
тогтоолын төсөл удирдамжийн  
төслийг боловсруулж гишүүдэд  
танилцуулж байна.**

Ажлын хэсгийн удирдамж  
батлах тухай. Монгол Улсын Их  
Хурлын тухай хуулийн 22 дугаар  
зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт,  
Монгол Улсын Их Хурлын хяналт  
шалгалтын тухай хуулийн 9 дүгээр  
зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын Байнгын хорооноос ТОГТООХ  
нь:

Монгол Улсын Их Хурлын  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын байнгын хорооны 2024 оны 10

дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1-д тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол, зорилтын хүрээнд туссан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн Ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрамд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулсугай гэсэн ийм удирдамж байгаа.

Та бүхэнд хүргэгдсэн байгаа. Тэгээд илүү дэлгэрэнгүй ажлын хэсгийн зорилго, ажиллах хугацаа, зохион байгуулалт, хамрах хүрээ, ажиллах бүрэлдэхүүн, танилцах, хянах, шалгах, гүйцэтгэх ажил, санал, дүгнэлт гаргах, тэгээд санхүүжилт гэсэн ийм 6 хэсэгтэй удирдамжийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Энэ удирдамжтай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Бид нар нэлээн энэ сэдвээр ярилцсан, тийм ээ.

Тэгвэл асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй учраас эндээс ч санал хураалт явна. Тийм ээ.

Та яах юм байна, тийм ээ. Тэгвэл Галбадрах гишүүнээр асуулт асууж, үг хэлэх гишүүдийг тасаллаа. Галбадрах гишүүн.

**Ж.Галбадрах:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд бид нар чинь нэлээн хэлэлцээд ингээд явсан. Тэгээд удирдамж их ийм ерөнхий гарсан харагдаж байна, тийм ээ, Би зүгээр ер нь энэ ажлын хэсэгт ороогүй. Нөгөө Боловсролын зээлийн санд орсон байсан. Тэгээд зээлийн сан дээрээ бид нар сонсоход зээлийн сангийн хүмүүс ирээд, бид нарт их тодорхой мэдээлэл өгсөн.

Тэгэхээр ойлголт нэлээн авсан учраас би энэ нүхэн жорлонгийн асуудал, тийм ээ, энэ талаар нэлээн мэдээлэл авахыг хүсэж байна.

Тэгээд зарцуулалт нь ямар хувьтай, хэдэн хувьтай явж байгаа юм, тийм ээ, тэгээд ер нь зураг төсөл, ТЭЗҮ нь 1, 2 дугаар үе шат нь ингээд хэрэгжсэн. Одоо 3, 4 рүүгээ орж байгаа. Яг юу нь өөрчлөгдөөд, яаж байгаа ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг сонсьё, авъя гэж бодож байгаа.

Тэгээд энэ ажлын дэд хэсэг хуралдсан байх. Тэгээд тэр дээр тараасан материал энэ тэр байдаг бол авъя. Түүнтэй холбоотой мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна. Тэгээд ер нь ашиглалт энэ тэрийг нь бүр их тодорхой, зурагтай, тэгээд видеотой тийм байдлаар бид нарт танилцуулбал би өөрөө хөдөөгийн сургуулиуд тойроод яваад үзээд байгаа. Тэнд очоод миний хараад байгаа юм яг тэр бэлэн болчихсон, хийгдсэн гэдгийг хараад байгаа зүйл, энд ингээд хийгдээд байгаа тэр энэ тэрийг харахад тийм их өндөр

төсөвтэйгөөр ингээд хийгдэх зүйл нь ямар байдаг юм бол оо гээд өөрөөр хэлбэл нэг тайлан сонсъё л гэсэн байдал ийм санал байна.

**Ч.Ундрам:** Өнөөдрийн манай хуралдаанд яг энэ асуудал дээр хуралдаанд оролцох ажлын хэсгийг танилцуулъя.

Наранбаяр Боловсролын сайд, Батцэцэг Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга энэ 2 хүн ирсэн байна.

Тэгэхээр ажлын хэсгийн хувьд бид нар хуралдаанд нэлээд мэдээлэл авчихсан байгаа. Үүнийг та Наранбаяр сайд, Ням-Очир дарга 2 Галбадрах гишүүнд хүргүүлээрэй.

Гэхдээ ерөнхийд нь ажлын явц ямар хэмжээнд байгаа вэ гэдгийг өнөөдөр тодорхой хэмжээнд танилцуулчихъя. Наранбаяр сайд танилцуулах уу? Ням-Очир дарга ярих уу?

Сайд ярья.

**П.Наранбаяр:** Яах вэ, өнөөдрийн байдлаар та бүхэнд нөгөө урьд нь танилцуулсанчлан нэг 796 ийм байгууламжаас ойролцоогоор 506 нь бүрэн дууссан ийм байдалтай байгаа.

Тэгээд Галбадрах гишүүний хэлсэнчлэн видеотой, жорлон болгон тэр ариун цэврийн байгууламж болгоноор нь бид нар зураг, хөрөгтэй нь ингээд явуулъя. Ашиглалтын өнөөгийн байдлыг хүргүүлье. Мэдээж үнэ, тэнд зарцуулагдаж байгаа төсөв бодитой зардал 2-ын энэ харьцаа. Энэ зүйл дээр ч гэсэн бид өөрсдөө энэ дээрээ нарийвчлан шалгаад, энэ үр дүнгээ хүргүүлье.

**Ч.Ундрам:** Нэмж Ням-Очир дарга тодорхой мэдээлэл ерөнхийдөө багцлаад гишүүдэд явцаа нэмээд ярьчихъя.

**Т.Ням-Очир:** Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламж болгох ажил сая сайдын хэлсэнчлэн 4 үе шатанд хуваагдаж хэрэгжихээр жагсаалт гарсан.

Одоогийн байдлаар 4 үе шатны жагсаалт эцэслэгдэн батлагдаж, 796 объект бүрэн солигдоход Монгол Улсын хэмжээнд 1 ч цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байр нүхэн жорлонгүй орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болох болно гэдэг ийм тооцоо судалгаа гарсан.

Өнөөдрийн байдлаар 506 объектыг бид нар байнгын ашиглалтад оруулахад 100 хувь бэлэн болгосон. Ашиглалтын үйл явцтай Боловсролын ерөнхий газрын ажлын хэсэг өнөөдөр яригдсан энэ цаг үед газар дээр нь танилцаад явж байгаа.

Эхний Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр 100 тэрбум төгрөг батлагдсан. Энэтэй эхний 1, 2 дугаар ээлж түлхүүр гардуулах нөхцөлтэй ... /минут дуусав/

**Ч.Ундрам:** Минут нэмж өгье. 4 номерт.

**Т.Ням-Очир:** 1, 2 дугаар ээлж түлхүүр гардуулах нөхцөлтэй зарлагдсантай холбогдуулаад санхүүгийн төсөв тооцоо дахиж хийгээд, Эрдэнэт үйлдвэрээс нэмэлт 60 тэрбум төгрөг нийтдээ 160 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжихээр тооцоо судалгааг гаргаж,

батлуулсан. Өнөөдрийн байдлаар энэ 506 объект ашиглалтад орсон. Санхүүжилтийн гүйцэтгэлд 74 тэрбум төгрөг гүйцэтгэсэн компаниуддаа олгогдчихсон явж байгаа.

Ингээд 3, 4 дүгээр ээлжийн зураг төсөв эцэслэгдэж байгаатай холбогдуулаад нийтдээ 142 орчим тэрбум төгрөгт энэ төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусах боломжтой байна гэсэн урьдчилсан төсвийн тооцоо, судалгаанууд бэлэн болсон.

Оndoо багтаад бид нар 80 хувьд хүргэх, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 80 хувьд хүргэх. 25 оны 6 сар гэхэд бүрэн дуусгасан байхаар төлөвлөлт гаргасан байгаа.

**Ч.Ундрам:** Хариулт хангалттай юу, Галаа гишүүн ээ. Галбадрах гишүүн. Танд ер нь нэмж тэгэхдээ материал өгье гэсэн байгаа шүү.

Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Ер нь маш өндөр дүнтэй төсөв байгаа шүү дээ. 160 тэрбум тийм ээ. Үүнээсээ 100-г нь аваад ингээд яваад энэ тэр тайланг аваад, бид нар чинь өнөөдөр сая төсөв яриад маш их асуудлууд гараад, боловсролын бид нар тооцоо хийгээд, яаман дээр шинээр барих сургууль 1 ч орсонгүй.

Тэгээд үргэлжлүүлж хийх төслүүд маань ч гэсэн их танагдаад, ингээд ороод ирчихсэн. Одоо бол яах вэ, тодотгол яригдана гэж байгаа. Тэгэхдээ бид нар, би зүгээр эд нарыг ингээд асуугаад, ингэж гаргаж ирээд байгаа боломж нь байгаад ингэдэг бол энэ төсөв нэгэнт Эрдэнэт үйлдвэрээс санхүүжүүлэгдсэн энэ төсөв байгаа учраас энэ дээрээс бид нар цаашаа сургууль, цэцэрлэг рүүгээ барихад

зарцуулах тийм боломж нь байдаг юм уу гэдэг талаас нь би нэг, тэгээд зүгээр зориулалт энэ тэр нь өөр болж байгаа энэ тэр гээд зүйлүүд байх байх. Тэгэхдээ үүнийг нэг тэр өнцгөөс нь бид нар харвал яасан юм гэдэг санал Байнгын хороон дээр тавьж байна.

**Ч.Ундрам:** Энэ төсөв нь нөгөө улсын нэгдсэн төсөв биш. Тухайн компанийн төсөвт бид нар тавиулаад, Улсын Их Хурлын тогтоолтойгоор хэрэгжүүлж байгаа ийм ажил байгаа юм.

Тэгээд энэ чинь маш олон сумдад хийгдэж байгаа. Тэгээд цэвэрлэх байгууламжтай, байгууламжгүй газрууд гээд тийм учраас төсөв нь ингээд нэлээн өндөр, бараг 800-аад сургууль, цэцэрлэг, дотуур байр учраас ийм байгаа. Гэхдээ бид нар Эрдэнэт үйлдвэрийн удирдлагуудтай энэ манай ажлын хэсэг уулзана. Уулзаад сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн усны чанартай холбоотойгоор хүсэлт эд нар тавих гээд байж байгаа юм.

Тэгэхээр Галаа гишүүн та наана нь уулзаад, тэр уулзалт дээр хамт орж болно. Эрдэнэт үйлдвэрийг бид нар нийгмийн хариуцлагын хүрээнд энэ боловсролын салбарт тодорхой хэмжээний дэмжлэг санхүүжилт нэмж хүсэх ийм төлөвлөгөөтэй байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр хамтрах боломжтой гэж хэлмээр байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Мөнхтуяа гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгаарай.



Ингээд 100 хувийн, 100 хувь зөвшөөрсөн байна, тийм ээ, саналаар батлагдлаа.

14.53 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

**Ажлын хэсгийн удирдамж батлах тухай.**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт, шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч О.Батнайрамдалд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2025 оны намрын ээлжит

чуулганы хугацаанд танилцуулсугай гээд хавсралтаар мөн энэ чинь 6 хэсгээс бүрдэж байсан тийм ээ. Мөн 6 хэсгээс бүрдэх удирдамжийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр удирдамжтай холбоотой асуух асуулт бүхий гишүүд нэрсээ өгнө үү? Боловсролын зээлийн сан дээр тийм ээ. Сарнай гишүүнээр тасаллаа. Ингээд болсон юм уу, тийм ээ.

Ганбаатар гишүүн асуулт асууя.

Би ажлын хэсгээ танилцуулаадахъя.

Наранбаяр сайд, Батцэцэг дарга нар дээр нэмэгдээд Боловсролын яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Энхбаяр, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа гээд ирсэн байна.

Ганбаатар гишүүн асуулт асууя.

**А.Ганбаатар:** Энэ Боловсролын зээлийн сан өөрөө Монгол Улсын ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэхэд маш чухал сан. Гадаад, дотоодын их сургуульд, тухайлбал дэлхийн топ 20 сургуульд тэнцсэн хүүхдүүд улсын зардлаар сурч байгаа. Эргэж ирээд төрдөө ажиллаад бие, сэтгэл хүчээ өгч байгаа.

Ерөнхийдөө сонгуулийн үеэр ч тэр, түүнээс ч өмнө, эдүгээ ч бас олон нийтийн анхаарлыг татаад, шударга бус явагдаж байна гэсэн шүүмжлэл гараад байгаа.

Тэгэхээр миний хэлэх гэж байгаа санал бол Төсвийн хууль дээр тусгасан 28.1-ийг бариад, олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийг явуулж өгөөч ээ гэж хэлэх гээд байгаа юм. Яг энэ тогтоол дээрээ гэдэг юм уу, энэ төсөв

дээр, тодотголоор ч орж магадгүй, тийм ээ.

Яах гээд байна вэ гэхээр Монголын Үндэсний радио, телевиз бол бид нарын хураамжийн мөнгөн дээр явж байгаа. Тэгээд тодорхой цагаа энэ хэлэлцүүлэгт зориулаад, Боловсролын зээлийн сан шударга явж байна уу, үгүй юу гэдгийг олон нийтэд, магадгүй тэр реалисти шоуны хэлбэрээр хүргэх юм бол олон нийт энэ нэг ойлголтоосоо цэгцэрнэ. Одоо нийт хүмүүс ойлгохдоо энэ арын хаалгатай ч юм уу, эсвэл чинээлэг айлын хүүхдүүд гэдэг юм уу, эрх мэдэлтэй хүүхдүүдийн хүүхдүүд яваад байгаа юм шиг ойлгодог. Гэтэл энэ чинь нөгөө Үндсэн хуулийн эрхээ зөрчөөд, хэрвээ тэнцсэн бол тэр чинь хэний ч хүүхэд явж болно шүү дээ. Хамгийн гол нь шалгуурыг нь хангасан, мерит зарчмаар явах ёстой.

Тэгэхээр үүнийг нээлттэй нэг удаагийн энэ намрын, хаврын шалгаруулалтаар гэх юм уу, намрынхаар байдаг юм уу, Батнайрамдал гишүүн энэ юуг ахалж байгаа юм байна лээ. Ажлын хэсгийг.

Тэгэхээр өөрөө энэ гол анхаарлын төвд авчирсан хүний хувьд ингэж хийвэл шударга байх болов уу. Энэ тогтоол хуулийнхаа журмаас нэг гажчихгүй болов уу гэсэн ийм санал байна.

**Ч.Ундрам:** Энэ ажлын хэсгийн удирдамжийн төсөл дээр яг нөгөө таны хэлсэнтэй яах вэ, уялдах юм гэж би бодоод байна л даа. 4.8-д олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах гээд орчихсон байгаа юм. Гэхдээ бид нар мэдээж боловсролын салбарын төсвийг хэлэлцүүлэх үеэр тусдаа яг энэ салбарыг бүхэлд нь, тэр дундаа ингээд тэтгэлгийг нь нэг салбар хэлэлцүүлэг, эд нар болгоод бас зохион байгуулж болно.

Тэгээд ажлын хэсгийн ахлагч Батнайрамдал гишүүн нэмэлт тайлбар өгье.

**О.Батнайрамдал:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд Ганбаатар гишүүний саналтай яг санал нэг байна. Та 25 оны төсөв дээр тусгагдсан дүнг ярьж байна л даа. Тэгэхээр 25 оны төсөв дээр, сая батлагдсан төсөв дээр Боловсролын зээлийн сан дээр 175,9 тэрбум төгрөг буюу 40,9 хувиар нэмж орж ирсэн.

Тэгэхээр энэ нэг талаасаа маш сайшаалтай. Боловсролын зээлийн санг тэр дундаа Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэмжийн тэтгэлэг, Засгийн газрын гэрээгээр гадаадад сурах тэтгэлэг, мөн гадаадад суралцах тэтгэлэг гээд яг гадаадад сурах Монгол залуучуудад олгох тэтгэлэг 103 тэрбум болж нэмэгдэж орж ирсэн байгаа юм.

Тэгэхээр энэ нэг талаасаа боловсрол дээр оруулж байгаа маш том хөрөнгө оруулалт. Энэ зээл юу 2025 оны төсөв дээр 51 тэрбумаар тэлж орж ирж. Тэгэхээр яг асуултын тэмдэг яг таны олон нийтээс асуугаад байгаа, аав, ээжүүдээс асуугаад байгаа, суралцагчдаас асууж байгаа зүйл. Энэ нэмж орж ирсэн энэ 175,9 тэрбум төгрөг болон зээлийн сангаар яг хэр шударга, нээлттэй очих вэ гэдэг л асуултын тэмдэг байгаа юм.

Тэгэхээр энэ ажлын хэсгийн хүрээнд сая Ундрам дарга хэллээ. Яг бид нар энэ ажлын хэсгийн удирдамжтай ч гэсэн яг таны саналыг бид нар яг 4.8 дээр энэ журмын хэрэгжилт дээр хяналтын хүрээнд ч гэсэн ер нь энэ талуудын оролцоог хангасан олон нийтийн хэлэлцүүлэг явуулъя. Магадгүй тэр шударга шалгаруулалтыг цаашиа явуулахын

тулд таны санал их сонирхолтой санал байна л даа. Яг ни ар талаасаа. Реалити шоу маягаар ч юм уу, ерөөсөө ард түмний нүдэн дээр, олон түмний нүдэн дээр яаж нээлттэй явуулаад, яг зөв хүүхдүүдтэй очиж байна гэдэг жишигийг бид нар яаж тогтоох вэ. Тэгэхээр энэ ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн иймэрхүү санал гаргаад, дараагийн энэ хавар явагдах шалгаруулалт дээр бүгдээрээ ач холбогдол өгч байгаад түүн дээр нэг жишиг гаргая гэж байгаа юм. Энэ жишгээр хэрвээ Боловсролын зээлийн сангийн энэ 2025 он дээр нэмж орж ирсэн тэр 50,1 тэрбум төгрөг тийм ээ. Илүү зөв хүндээ очсон ийм жишигийг тогтоож чадах юм бол цаашидаа ч гэсэн үе үе, жил болгон тэр голдирол руу оруулах энэ ажлын хэсгийг нь бүгдээрээ санал гаргаад, яг дараа жил энэ 25 оны төсөвтэй уялдуулаад үүнийг бид нар хийж үзэх хэрэгтэй гэж бодож байна.

Тэгэхээр таны саналыг 100 хувь дэмжиж байна. Бүгдээрээ яг энэ ажлын хэсгийн хүрээнд удирдамжид орсны дагуу бүгдээрээ энэ дээр санал гаргаад хийж үзэх хэрэгтэй гэдэгтэй 100 хувь санал нэг байна.

**Ч.Ундрэм:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**А.Ганбаатар:** Баярлалаа. Энэ 4.8-ыг барьж яривал яг онож байна, тийм ээ, энэ хүрээндээ хийчхээж болохоор байна шүү дээ. Тэгэхээр бид нар Ди Питиинд энэ саналыг оруулж болох уу? Иргэдээс эсвэл бид нар ажлын хэсгээс өөрсдөө оруулаад. Ди Питиин, ди парламент руу үүнийг ийм олон нийтийн хэлэлцүүлэг болгож өгөөч ээ гээд олон нийтээс дэмжлэг саналыг нь авах гээд байхгүй юу. Хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу бас мэдэж авмаар байна шүү дээ, тийм ээ. Тийм эрх зүйн

зохицуулалт боломж нь байгаа юм болов уу. Сайд мэдэх байх даа.

**Ч.Ундрэм:** Мэдээж, онлайнаар питиин хийгээд яг тодорхой асуулт, санал тавиад ингээд олон нийтийн саналыг аваад, ямарваа нэгэн ажил Их Хурлаас хийж болно. Гэхдээ нэгэнт ийм ажлын хэсэг байгуулагдчихсан байгаа учраас энэ ажлын хэсэг дээрээ бид нар зохион байгуулаад явчихвал илүү зүгээр юм болов уу гэж би бодоод байна.

Гэхдээ Батнайрамдал гишүүн Ганбаатар гишүүнтэй уулзаад үүнийг өшөө яаж тийм олон нийтэд нээлттэй зохион байгуулах вэ. Тэр тал дээр нь та 2 хамтраад ажиллахад боломжтой байх гэж бодож байна, тийм ээ.

Маш чухал тийм санал байна. Олон нийтэд нээлттэй. Одоо тэгэхгүй бол энэ сангуудын үйл ажиллагаанд олон нийт итгэх итгэл ер нь байхгүй болчихоод байна шүү дээ. Тийм учраас үүнийг илүү нээлттэй зохион байгуулах нь зөв гэж бодож байна.

Сарнай гишүүн. Дараагийн асуулт.

**М.Сарнай:** Өдрийн мэнд. Боловсролын зээлийн сан олон нийтийн хүрээнд аягүй их анхаарал татаж байгаа сэдвүүдийн нэг. Тэгээд Боловсролын зээлийн ажлын хэсгийн удирдамж дээр ажлын хэсгийн хүрээнд ямар ажлыг үндсэндээ хийх вэ гэдэг асуултыг ажлын хэсгийн дарга Батнайрамдалаас асуумаар байна. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Ажлын хэсгийн дарга Батнайрамдал гишүүн хариулъя.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Тэгэхээр ажлын хэсгийн удирдамж бас олон нийтэд энэ ил тавигдах байх, тийм ээ, тавигддаг болов уу.

Батлагдсаны дараа. Тийм ээ, тэгэхээр. Тэгэхээр ямар ч байсан Байнгын хороогоор аж ажлын хэсгийн удирдамж орж батлагддаг болсон байна. Тэгэхээр ил болчих байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ хүрээнд яах вэ, үндсэндээ яг өнгөрсөн хугацаанд гарсан зөрчил дутагдал, тийм ээ, үүний хүрээнд ч гэсэн ажлын хэсгийн хүрээнд бид нар мэргэжлийн хуулийн байгууллагын дүгнэлтийг авъя гэж байгаа. Ер нь энэ зөрчил дутагдлыг зүгээр ингээд нэг талаас яриад байх юм уу, эсвэл мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргаад, цаашидаа авах арга хэмжээнд илүү ойлгомжтой болгох уу.

Тэгээд дээрээс нь олон нийт ч билүү энд энэ тал дээр мэдээллийг мэдэж байгаа. Ер нь Авлигатай тэмцэх газар болон Прокурорын ерөнхий газар хамтарсан том ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газраас гаргаж байсан.

Тэгэхээр тэр ажлын хэсгийн дүгнэлтийг авч үзье. Тэгээд энэ гарсан зөрчил дутагдлыг нэг мөсөн цэгцлээд, тэгээд цаашидаа сая түрүүн ярьсан дараа дараагийн шалгаруулалтаас эхлээд хэрхэн ил тод болгох вэ. Энэ ажлын хэсгийн хүрээнд түүний шийдлийг гаргаад нэг магадгүй энэ Монгол Улсын Засгийн газрын 22 тусгай сан дотор хамгийн ил тод, нээлттэй, шударга, шалгаруулалттай сангийн нэг жишиг болох ёстой л гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийн удирдамж ч гэсэн нээлттэй оруулж өгсөн. Мөн олон нийтдээ бид нар хэлэлцүүлэх ёстой. Тэр аав, ээж нарын, суралцагчдын дуу хоолойг бид нар авах ёстой. Тэд нарт тулгамдаж байгаа асуудлууд, цаашидаа одоо практик талаасаа шийдлүүд нь юу байх вэ, тийм ээ. Тэгэхээр энэ ажлын хэсгийн

хүрээнд тэр тэдний саналуудыг нэгтгэж, тийм ээ, дараа дараагийн шалгаруулалт журам дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тэр ажлыг энэ ажлын хэсгийн хүрээнд хий гэсэн удирдамжийн хүрээнд ажлуудыг тусгасан байгаа. Баярлалаа.

#### **Ч.Ундрам:** Тодруулах уу?

Би нэг жижигхэн асуулт асуух гэсэн юм. Энэ Боловсролын зээлийн сангийн 2025 оны төсвийг харж байхад энэ урианхай, тува, цаатан иргэдэд 4,5 тэрбум төгрөг гээд төсөвлөгдсөн байгаад байгаа юм. 24 онд 4 тэрбум төгрөг. Энэ яг яаж тэр урианхай, тува, цаатан хүмүүст олгогддог юм бэ. Яг урианхай гэдгийг нь яаж мэдэх вэ. Үүнийг асуух гэсэн юм.

Сийлэгмаа дарга хариулъя. 5 дугаар микрофон.

**О.Сийлэгмаа:** Бүгдэд нь өдрийн мэнд. Ундрам гишүүний асуултад хариулъя.

2018 оны Ерөнхийлөгчийн зарлигаар үндэслээд үндэсний цөөнхөд тодорхой хэмжээний сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа ийм хөтөлбөрүүд байгаа. 2021 оноос Боловсролын зээлийн сан тува суралцагчид, цаатан гэж 2 суралцагчдын үндэстэнд, ястнуудад санхүүжилт олгож ирсэн.

Сая 24 оны 102 дугаар тогтоолоор нэмээд ороод ирсэн урианхай гэдэг үндэстнийг яаж хязгаарлах, юу квотоо яаж тогтоох вэ гэдэг асуудал яаманд 2024 оны 6 сард албан тоот явуулж ярилцсан. Үүнийг Үндэсний статистикийн газраас гаргасан нийт 18-24 насны, 18-30 насны 5000 орчим урианхай иргэдээс яг 30, 30 хувиар нь суралцах ийм

санхүүжилтийг төлөвлөж, 25 ондоо тусгасан байгаа.

**Ч.Ундрaм:** Тэгэхээр энэ урианхай, тува, цаатай иргэд маань их, дээд сургуульд тэнцээд, тэгээд Боловсролын зээлийн санд хүсэлт гаргах юм бол та бүхэн зээл олгоно гэсэн үг үү?

**О.Сийлэгмаа:** Тэтгэлэг олгох гэж байгаа, энэ санхүүжилтээр. Энэ дээр ҮАБЗ-ийн нууцын гэрээтэй тогтоол байдаг юм байна лээ. Тэр тогтоолоор яг аль аймгийн, аль үндэстний, хэн гэдэг суралцагчийг суралцуулах вэ гэсэн албан бичгийн хавсралтаар суралцагчдын мэдээлэл ирдэг. Суралцагчид маань сургуульдаа хүсэлт гаргаад, тухайн суралцагчийн алийг нь ямар мэргэжлээр сургах вэ гэдэг дээр илүү ҮАБЗ-ийн албан тоот дээр чиглэл ирдэг юм.

**Ч.Ундрaм:** Асуулт дууслаа.

Их Хурлын гишүүдээс саналтай гишүүд байвал нэрсээ өгье. Байхгүй байна, тийм ээ. Галбадрах гишүүнээр тасалъя.

Галбадрах гишүүн саналаа хэлье.

**Ж.Галбадрах:** Тэгээд би нөгөө өмнөх дэд ажлын хэсэгт ороод мэдээлэл авчихсан байсан учраас сая асуулт асуусангүй. Энэ дээр ер нь санал хэлэх юм бол зээлдэгч тэр оюутантай хийх гэрээ дээр л бид нар маш сайн ажиллах ёстой гэж ингэж бодож байгаа. Тэр гэрээний талаар нэлээн сайн тусгаад явуулах, тэгээд гэрээг нь биелүүлэх, жишээлбэл багш нарын зээл, багш мэргэжлээр сурлаа.

Тэгээд аль аймгийн, аль сумаас ирээд сурч байна, тэгээд бид нар төлбөрийг нь хөнгөлж байна гээд л ингээд л хэлж байна. Тэгвэл тэр хүүхэд

оюутан төгсөөд тэндээ заавал очиж ажиллах ёстой гэдэг зүйлийг өгөх ёстой.

Нөгөө талаас зүгээр нэг зээл өгөөд 4 жилийн турш дансанд нь мөнгө хийгээд яваад байдгаар биш, ер нь өгөх тоолонд тэр гардуулж өгч байгаа үйл явц, энэ тэрийг нэлээн церемоны, тийм ээ, тийм ёслол төгөлдөр хийх ч гэдэг юм уу, бөөнөөр нь оруулж байгаа тэр үүргүүдийг нь ингээд ойлгуулж ярих, тэгээд энэ эцсийн дүнд энэ чинь үүнийг бид нар хасаж болохгүй их сайн нэмээд энэ ялангуяа дотооддоо энэ их эрэлт хэрэгцээтэй байгаа эмч, багш, инженер гэсэн ийм чиглэлээр бид нар нэмэх ёстой.

Одоо мега төслүүд явна гэж байгаа бол инженерүүдэд бид нар энэ зориулсан юмнууд энэ тэрийгээ явц дундаа сайжраад гарч ирээд ингээд явах байх гэж ингэж хараад байгаа.

Тэгэхээр тэр юман дээр гэрээ, зээлдэгчтэй л тэр гэрээг сайн хийгээд, тэгээд тэрийг нь зөвхөн ингээд мөнгөн дүн буцааж өгнө шүү гэхээсээ илүү тэр хүмүүсийн ухамсарт нь гэдэг юм уу сайн ойлгуулах. Чи энэ хүсэлтийг тавиад тэгээд эцсийн эцэст энэ тэтгэлэг авч сурсныхаа хүчээр чи тэр чанартай боловсрол аваад, сайн мэргэжил эзэмшсэн бол энэ үр дүнгээ гаргаж, энэ гэрээний дагуу тэр ажиллах ёстой талууд нэг 5 жил ажиллана энэ тэр гээд л журам дээрээ тэр мэргэжлээсээ хамаараад янз янз байх байх. Тэрийгээ яг ингээд биелээд л байна шүү гэдгийг нь сайн хэлж өгөх гэдэг зүйлийг.

Тэгээд тэгэхийн тулд зээлийн сан дээрээ ийм юунуудыг нь хариуцсан ийм тэтгэлэгт оюутнуудыг араас нь зүгээр нэг мөнгө шилжүүлдэг нягтлангууд байхаасаа илүү чиглүүлэгч тийм, карьер чиглүүлэгч гэж нэг

байдаг шүү дээ. Оюутнуудыг ингээд яваад байдаг шиг кэйр хийгээд яваад байх тийм мэргэжилтэн хүмүүс энэ тэр аваад, тэгээд яаж байна, ийж байна гэдэг юмны сурлагынх нь явцыг нь ингээд нэг анхаараад байдаг. Зүгээр хэдэн хүнд ингээд яаж хүрэлцэж явах нь вэ тэр талын хүмүүс байвал энэ нөгөө эргэн төлөлт их сайн байдаг.

Нөгөө талаас нэгэнт тэтгэлэг авсных чанартай яваад сураад төгссөн нь л дээр байдаг.

Дундаасаа гарах, энэ тэр шантрах оюутан чинь жижиг жижиг зүйл дээр тулгуурлаад шантраад байдаг бол тэрийг нь хийж өгч байдаг тийм хүмүүсийг хэдүүлээ энэ зээлийн сан дээрээ оруулах талаар анхаарвал зүйтэй байна аа гэж ингэж бодож байна.

Баярлалаа.

**Ч.Ундрам:** Баярлалаа.

Ирцэд Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Ганбатын Хосбаяр ирсэн байна. Ирц ингээд 80 хувьтай болж байна.

Гишүүдийн саналыг Ганбаатар гишүүний саналыг тийм ээ, Галбаяр гишүүний саналыг энэ тогтоол, удирдамжийн төсөлд тусгая.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Удирдамж 100 хувийн саналаар батлагдлаа.

15.11 цаг

Асуудлыг хэлэлцэж дууслаа.

Баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан  
өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ